



Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар

АУДИТЫН ХУРААНГУЙ
ТАЙЛАН

НИЙЦЛИЙН АУДИТ

АУДИТЫН СЭДЭВ:

ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ

АУДИТЫН КОД:

ХЭА-2025/14-22/ШТА-НА

ТӨРИЙН САНГИЙН
ТОГТОЛЦОО БҮРДСЭН Ч
ХОЛБОГДОХ ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ
ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Тайланг хүргүүлсэн байгууллага:

Үндэсний аудитын газар, Хэнтий аймгийн Иргэдийн
төлөөлөгчдийн хурлын дарга, аймгийн Засаг даргын
Тамгын газар, Норовлин, Хэрлэн сумын Засаг дарга

Нэмэлт мэдээлэл, мэдээллийн эх сурвалж:

Хэнтий аймаг, Хэрлэн сум, Аймгийн Засаг даргын
Тамгын газрын байр, Хэнтий аймаг дахь Төрийн
аудитын газар,

E-mail: khentii@audit.gov.mn, Audit.mn

Чингис хот
2026 он

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны “Аудитын сэдэв батлах тухай” 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө”-г үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилго, зорилтууд, хамарсан хүрээ:

Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн хэрэгжилтэд аудит хийж, төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж байгаа дүрэм, журам, холбогдох хууль тогтоомжийн нийцлийг сайжруулах, төрийн сангийн бүтэц, зохион байгуулалт, ажлын чиг үүргийн хуваарилалтыг оновчтой болгох, цахим системийн үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх талаар дүгнэлт, зөвлөмж боловсруулан Монгол Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Төрийн сангийн тогтолцоо оновчтой бүрдсэн эсэх;
- ✓ Төрийн сангийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх.

Аудитаар төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааг тодорхойлсон бодлого, хууль тогтоомжийн нийцэл, Төсвийн ерөнхийлөн захирагч болон Төрийн сангийн удирдлагын цахим системийг /цаашид ТСУЦС гэх/ ашигладаг бусад төрийн байгууллагуудын 2023-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, бүтцийн зохион байгуулалт, чиг үүрэг оновчтой эсэх, хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүн, үр нөлөөнд үнэлгээ хийлээ.

Ерөнхий мэдээлэл:

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.40-д “төрийн сангийн үйл ажиллагаа гэж төсөв, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнахыг” гэж тодорхойлж, мөн хуулийн 36, 37 дугаар зүйлд төрийн сангийн тогтолцоо, нийтлэг чиг үүргүүдийг хуульчилсан байна.

Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолын дагуу аймгийн Төрийн сангийн хэлтэс 8, сум, тосгоны Санхүүгийн албанд 83, нийт 91 албан хаагч төрийн сангийн үйл ажиллагааг явуулж, нийгмийн үйл ажиллагааг бүхий л салбарын хүрээнд хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж, төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажил үйлчилгээний санхүүжилтийг хууль, эрх зүйн хүрээнд үр ашигтайгаар хуваарилан зарцуулахад хяналт тавин ажиллаж байна.

Сангийн сайдын 2021 оны 96 дугаар тушаалын дагуу төрийн сан, төсвийн байгууллагын төлбөр тооцоог цахимаар хийх, хяналт тавих боломжийг бүрдүүлснээр төсвийн байгууллагын төлбөр тооцоо бүрэн цахим болсон байна. Аймгийн төсвийн 38, сумын 158 байгууллага 2023-2025 онуудад нийт 1,089,066.8 сая төгрөгийн 336455 гүйлгээг хийж, цахим системээр хяналт тавин ажилласан байна.

Мөн орон нутгийн төсвийн 61, улсын төсвийн орон нутаг дахь 116 байгууллага, 67 төсөл, сан, 23 төрийн сангийн нэгж, 22 орон нутгийн өмчит байгууллага, нийт 289 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэн ажилласан байна.

АУДИТЫН ГОЛ ҮР ДҮН:**БҮЛЭГ 1. ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО ОНОВЧТОЙ БҮРДСЭН БАЙНА.****1.1. Холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн баталсан төрийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн актыг мөрдөн ажиллаж байна.**

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.40-д “Төрийн сангийн үйл ажиллагаа гэж төсөв, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах”-аар төрийн сангийн үйл ажиллагааг тодорхойлж, Засгийн газрын 2014 оны 326, 2019 оны 88 дугаар тогтоолуудаар сумдын Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг нормативыг, Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн албан хаагчид болон сумын Санхүүгийн албаны албан хаагчдын ажил үүргийн жишиг зааврыг тус тус баталсан байна.

Засгийн газрын 2015 оны 24 болон 2023 оны 444 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-аар төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох, төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулж, Сангийн сайдын 2024 оны 256 дугаар тушаалаар Засгийн газрын удирдлагын мэдээллийн системд нэвтрэх эрх бүхий хэрэглэгчдийн ажил үүргийн хуваарь, систем дээр хийгдэх үйл ажиллагаа, Сангийн сайдын 2024 оны 255 дугаар тушаалаар Төрийн сангийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр шуурхай, ил тод, үр ашигтай хэрэгжүүлэх, хэрэглэгчдийн эрхийн тохиргоо хийх, цахим системийн үйл ажиллагааны зааврыг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.


1.2. Төрийн сангийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх зохистой бүтэц бүрдсэн ч хүний нөөц тогтворгүй байна.

Засгийн газрын 2021 оны 377, 2025 оны 29 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын захирамжаар Засаг даргын Тамгын газрын бүтцэд Санхүү, төрийн сангийн хэлтсийг 8, Засгийн газрын 2014 оны 326, 2019 оны 88 дугаар тогтоолын дагуу сумын Засаг даргын тамгын газрын даргын тушаалаар Засаг даргын Тамгын газрын бүтцэд Санхүүгийн албыг 4, тосгоны Захирагчийн захирамжаар ЗАА-ны бүтцэд Санхүүгийн албыг 3 албан хаагчийн орон тоотойгоор баталж байна.

Үүнээс Норовлин сумын Засаг даргын 2023 оны А/129 дүгээр захирамжаар Санхүүгийн албыг 5 албан хаагчийн орон тоотойгоор баталж байсан бол сумын ЗДТГ-ын даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар 4 албан хаагчийн орон тоотой болгож 1 нягтлан бодогчийн орон тоог хасаж баталсан нь Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив”-ын 2.1 дэх хэсэгтэй нийцэхгүй байна.

Нийт сумдын ЗДТГ, тосгоны захирагчийн ажлын албаны бүтцэд Санхүүгийн албанд 2023 онд 84, 2024 онд 84, 2025 онд 83 албан хаагчийн орон тоотой ажиллахаас 2023 онд 19, 2024 онд 13, 2025 онд 7 албан хаагчийн орон тоо дутуу ажилласан байна.

Дүрслэл 1. 2023-2025 онд дутуу ажилласан орон тоо




2026 оны 5 дугаар сарын байдлаар Санхүүгийн албаны дарга 6, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн 5, нягтлан бодогч 2 орон тоо дутуу ажиллаж байна.

Хүний нөөцийн тогтворгүй байдлаас шалтгаалан төрийн албыг тасралтгүй явуулах шаардлагын дагуу албан тушаалын тодорхойлолтод заагдаагүй чиг үүргийн албан тушаалыг түр орлон гүйцэтгэх зайлшгүй шаардлага үүсэж байна.

2023 онд 5 санхүүгийн албаны даргын сул орон тоог 3 нягтлан бодогч, 2 бусад албан хаагч /татварын улсын байцаагч, боловсролын салбарын нягтлан бодогч/ түр орлон гүйцэтгэсэн бол 10 төсөв, төрийн сангийн мэргэжилтний сул орон тоог 9 нягтлан бодогч, 1 нийгмийн даатгалын мэргэжилтэн түр орлосон байна. 2026 оны байдлаар 6 санхүүгийн албаны даргын сул орон тоог 1 төсөв, төрийн сангийн мэргэжилтэн, 4 нягтлан бодогч, 1 боловсролын салбарын нягтлан бодогч түр орлосон байна.

Дүрслэл 2. Сул орон тооны албан тушаалыг түр орлон гүйцэтгэсэн байдал /2026 он/



Бүндэр сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нь санхүүгийн албаны даргын ажлыг түр орлон гүйцэтгэж байгаа нь Сангийн сайдын 2024 оны 255 дугаар тушаалаар баталсан "Төрийн сангийн цахим системийн заавар"-ын 2.7, 256 дугаар тушаалаар баталсан "Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн систем мөрдөх заавар"-ын 6.9 дэх хэсэгт заасантай нийцэхгүй байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 271, 2022 оны 335 дугаар тогтоолоор Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга болон албан хаагчдын, 2025 оны 208 дугаар тогтоолоор сумын Санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг баталсан нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйл, Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоол, Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар тодорхойлсон нийтлэг чиг үүрэгтэй нийцэж байна.

Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 208 дугаар тогтоолоор сумын Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогч, Төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлахыг сумын Засаг дарга, Засаг даргын тамгын газрын дарга нарт даалгасан байна. Тогтоолын дагуу зарим сум, тосгоны Санхүүгийн албаны дарга болон Төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлаагүй байна.

Төрийн сангийн удирдлагын цахим систем, Төрийн албаны цалингийн нэгдсэн систем, Эрхийн бүртгэлийн системийн 44 хэрэглэгчийг хамруулсан судалгаанаас үзэхэд цахим систем нь мэдээллийн аюулгүй байдал, ажлын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж, орон зай үл хамааран төрийн сангийн үйл ажиллагааг явуулах боломж бүрдсэн байна.

Харин цахим системийн ашиглалтын талаар шаардлагатай сургалтыг зохион байгуулах, системийн уялдаа холбоог илүү боловсронгуй болгох, интернэтийн хурдыг нэмэгдүүлэх, сарын эцсийн тайлангийн үеийн ачааллыг бууруулах зэрэг саналыг ирүүлсэн байна.

БҮЛЭГ 2. ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД МӨРДӨГДӨХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ЭРХ ЗҮЙН АКТЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

2.1. Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олголт нь батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжсэн боловч журамд заасан хугацаа, баталгаажуулах маягт, баримтжуулалтын шаардлагыг хангаагүй байна.

Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 2.5.1, 2.5.3, 2.6.1, 2.6.2, 2.7.1-д зааснаар төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийг тухайн сарын ажлын эхний 5 өдрийн дотор, орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг ажлын 2 өдрийн дотор холбогдох хавсралтад заасан маягтаар баталгаажуулан олгохоор зохицуулсан байна.

Сангийн яам Улсын төсвөөс аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг тухайн оны Төсвийн тухай хуульд заасан хэмжээгээр бүрэн олгосон ч 2024 онд 2, 6, 7 дугаар саруудаас бусад саруудад 33,656.2 сая төгрөгийн санхүүжилтийг ажлын 1-7 өдрөөр, 2025 онд 6 дугаар сараас бусад саруудад ажлын 1-18 хүртэл өдрөөр хугацаа хоцроож санхүүжилтийг шилжүүлсэн байна.

Санхүү, төрийн сангийн хэлтэс аймгаас сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 2024 онд 2 дугаар сараас бусад саруудад ажлын 1-11 өдрөөр, 2025 онд бүх саруудад ажлын 1-12 өдрөөр хугацаа хэтрүүлж олгосон нь Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 2.6.1-т заасан хугацааг зөрчсөн байна.

Улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг хийхдээ 2024, 2025 онд бүх сард ажлын 1-18 өдрөөр хугацаа хэтрүүлж шилжүүлсэн байна. Сангийн яамнаас улсын төсөв хүндэрсэн гэсэн шалтгаанаар баталсан хуваарийг баримтлалгүй зарим төрлийн зардлын санхүүжилтийн эрхийг олгоогүйгээс ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээ нь хэрэгжсэн боловч аймгийн ОНХС 651.1 сая төгрөг, 13 сумын ОНХС 1,338.1 сая төгрөг, нийт 1,989.9 сая төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор Хэрлэн сум 2023 онд 303.9, 2024 онд 1,054.6, 2025 онд 4,354.3 сая төгрөгийн орлогыг аймагт төвлөрүүлэхээр баталсан ч аймгийн Засаг даргын баталсан сумдаас аймагт төвлөрүүлэх орлогын хуваариас ажлын 5-45 өдрөөр хугацаа хоцроож шилжүүлсэн байна.

Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын дагуу аймаг, сумдын ИТХ-аас баталсан төсвийн хүрээнд аймаг, сумын Засаг даргын баталсан зарлагын хуваарийн дагуу эдийн засгийн ангилал, хөтөлбөр, арга хэмжээгээр ангилж, холбогдох маягтуудаар баталгаажуулан санхүүжилтийн эрхийг олгохоор түүвэрт хамрагдсан сумдаас Баянхутаг, Мөрөн, Гурванбаян, Өмнөдэлгэр сумд тус журмын хавсралт маягтуудыг хөтлөн баримтжуулаагүй, төсөв захирагчаар хянуулалгүйгээр санхүүжилтийг олгосон байна.

2.2. Төрийн сангийн нэгдсэн данс, төлбөр тооцооны үйл ажиллагаа нь хууль, журмын дагуу баталгаажиг байгаа боловч зориулалт бус зарцуулсан, зардлын эдийн засгийн ангилал зөрүүлсэн зөрчилтэй гүйлгээг баталгаажуулсаар байна.

Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.6.1-д бэлэн мөнгөн зарцуулах зориулалттай картын данстай байж болно гэж журамласан ч аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумын Санхүүгийн алба, төсвийн байгууллагын дарга, нягтлан бодогч нар мөрдөж ажиллаагүй, бэлэн мөнгөний гүйлгээ хийх дансыг хааж, зарцуулалтыг хориглосноос нярвын хувийн харилцах дансанд шилжүүлж бэлэн мөнгө зарцуулсан, тайлан гаргаагүй, зарцуулалтын баримт дутуу зэрэг 68.9 сая төгрөг 9 зөрчлийг гаргасан байна.

Төсвийн байгууллага нь бэлэн мөнгө зарцуулах зориулалттай картын данс нээгээгүй, жижиг мөнгөн санг байгуулахгүйгээр нярвын хувийн харилцах дансаар бэлэн мөнгийг зарцуулж байгаа нь Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.6.1, 3.6.4 дахь заалтуудыг зөрчиж байна.

Сангийн сайдын 2016 оны 431 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн сан төлбөр тооцоог гүйцэтгэхэд үндэслэх баримт бичгийн жишиг, заавар”-ын дагуу төлбөр тооцоо, зарлагын гүйлгээг эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулан гүйцэтгэж байгаа боловч 91 байгууллага 2,893.3 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан, 17 байгууллага 124.2 сая төгрөгийг зардлын эдийн засгийн ангиллыг зөрүүлэн зарцуулсан, 3 байгууллага 55.6 сая төгрөгийг анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн зөрчлийг гаргасан байна.

Мөн Сангийн сайдын 2023 оны 444 тоот тушаалаар баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.5.8-д "Төрийн сан нь сар бүрийн эцсийн ажлын өдөр 14 цагт зарлагын гүйлгээг хаана" гэсэн заалтыг зөрчиж сарын сүүлийн өдрийн 14 цагаас хойш 2024 онд 10,163.3 сая төгрөгийн 171 гүйлгээ, 2025 онд 694.2 сая төгрөгийн 127 гүйлгээг хийсэн байна.

Энэ нь төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй, гүйлгээг хянах, батлах эрх бүхий албан тушаалтны ажлын хариуцлага сул байгаагаас шалтгаалж байна.

Төрийн сангийн удирдлагын цахим системээр хийсэн гүйлгээнээс үнийн дүн алдаатай, бэлтгэн нийлүүлэгч давхар бүртгэгдсэн, дансны дугаар бүртгэлгүй, кодын блонкын данстай тохирохгүй байх, төсвийн багц хүрэлцэхгүй, харилцагчийн данс мэдээлэл алдаатай зэргээс шалтгаалан 2023 онд 4,433.9 сая төгрөгийн 2582, 2024 онд 3,950.1 сая төгрөгийн 1836, 2025 онд 5,773.1 сая төгрөгийн 1987 гүйлгээ амжилтгүй болсон байна.

Мөн анхан шатны баримт дутуу, төлбөрийн хүсэлтийн дүн анхан шатны баримтын дүнгээс зөрүүтэй, төрийн сангийн ажилтан батлахгүй 72 цаг болсон, төсөв хүрэлцэхгүй, хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал буруу зэргээс шалтгаалан Төрийн сангийн удирдлагын цахим системээр хийсэн гүйлгээнээс 2023 онд 8,314.6 сая төгрөгийн 4866, 2024 онд 11,864.0 сая төгрөгийн 3824, 2025 онд 8,623.5 сая төгрөгийн 3189 гүйлгээг буцаасан байна.

Сангийн сайдын 2023 оны 444 тоот тушаалаар батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4.21-т "Төсвийн байгууллага орлогын хуулгыг өдөр тутам хянаж, тодорхой бус орлогын талаар нягталж, орлого бууруулах гүйлгээг гаргахдаа холбогдох нотлох баримт болон орлогын дэлгэрэнгүй хуулгыг төлбөрийн хүсэлтийн хамт хавсаргаж ажлын 3 өдрийн дотор төрийн санд мэдэгдэн залруулах хүсэлт гаргана" гэснийг зөрчиж 2024 онд 502.0 сая төгрөгийн 9 гүйлгээг 7 хоногоос 10 сарын дараа залруулсан байна.

Энэ нь дансны ангилал зөрүүлсэн татварын орлого, нэр данс зөрүүтэй гүйлгээг залруулах хүсэлтийг тухайн байгууллагаас журамд заасан хугацаанд ирүүлдэггүйгээс шалтгаалсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг төсвийн байгууллагаас авч аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг гарган нэгтгүүлж байна.

Төсөв хоорондын тооцооны тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээнд залруулга хийлгэх хүсэлт, барьцаа хөрөнгийн зардлын гүйцэтгэл, захиалагчийн хяналтын гүйцэтгэл маягуудыг цаасаар хөтөлж баталгаажуулдаггүй нь Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын дөрөв дэх хэсэгтэй нийцэхгүй байна.

Энэ нь төрийн сангийн дансны хуулганы орлого, зарлагын гүйлгээ, төсвийн хэлбэлзэл зэргийг үндэслэн зөвхөн цахимаар тооцож, мэдээ тайланг гаргаж байгаагаас шалтгаалан төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, төсөв хоорондын тооцоог хугацаанд нь үнэн зөв илэрхийлэх боломжгүй болгож байна.

2.3. Төрийн сангийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхгүй байна.


Төрийн сангийн үйл ажиллагаанд хийх дотоод хяналтын төлөвлөгөөг жил бүр аймгийн Засаг даргын захирамжаар батлуулж, төлөвлөгөөний дагуу 2023 онд 6 сум, 2 тосгонд хяналт хэрэгжүүлэхээс 4 суманд, 2024 онд 6 сум, 1 тосгонд хяналт хэрэгжүүлэхээс 2 суманд ажиллаж, төлөвлөгөөг 40 хувиар биелүүлсэн байна. 2025 онд сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх, Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг хянах, ААН-үүдэд сургалт зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг бүх сум, тосгонд хэрэгжүүлсэн байна.

Дотоод хяналтын тайлангаас үзэхэд өмнөх оны дотоод хяналтын тайлан, зөвлөмжийн биелэлтийг хянаагүйгээс дараагийн жилд гүйцэтгэсэн дотоод хяналтаар журмын 6.1.2, 6.1.6, 6.1.8-д заасан чиглэлээр зөрчил давтагдсан байна.

Дотоод хяналтын 2023, 2024 оны төлөвлөгөөг 60 хувиар дутуу хэрэгжүүлсэн, хяналт хэрэгжүүлэхдээ өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлээгүйгээс дараа онд зөрчил давтагдсан байна.

Сангийн сайдын 2014 оны 65, 2024 оны 254 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийн үнэлгээг нэгтгэн журамд заасан хугацаанд багтаан Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлсэн байна.

Дүрслэл 3. Төрийн сангийн нэгжийн эрсдэлийн түвшний үнэлгээ



Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн нь харьяа төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн эрсдэлийн үнэлгээг нэгтгэхдээ журмын дагуу нягтлах, дахин үнэлэх арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байна.

Энэ нь тухайн жилд “Бага” болон “Дунд” эрсдэлийн түвшинтэй үнэлэгдсэн сумдын төрийн сангийн үйл ажиллагааны чиглэл нь дотоод хяналтаар зөрчил гарч, зөвлөмж авч байгаагаар илэрч байна.

Иймд харьяа төрийн сангийн нэгжээс ирүүлсэн эрсдэлийн үнэлгээг нэгтгэхдээ дахин нягтлах, бодит байдалд нийцүүлэх, үнэлгээнд үндэслэн эрсдэлд суурилсан дотоод хяналтыг хэрэгжүүлж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай байгааг харуулж байна.

Өдөр тутмын дотоод хяналтыг аймгийн төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн ЗГСУМС-ээр дамжуулан түүвэр байдлаар сонгон авч хяналтыг хэрэгжүүлж, энэ талаар дотоод хяналтын тайланд тусгахаар журамд заасан боловч 2023-2025 онуудад өдөр тутмын дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Өмнө нь 2018 онд гүйцэтгэсэн "Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн" аудитаар аймгийн Засаг даргад 3, аймгийн ЗДТГ-ын СТСХ-т 4 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна. Зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан СТСХ-ийн даргаар батлуулсан байна. Зөвлөмжийн биелэлтийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн даргын 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 3/1441 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

- ❖ Норовлин сумын Засаг даргын Тамгын газрын дарга Засгийн газрын тогтоолоор баталсан жишиг нормативыг зөрчиж, бүтэц орон тоог батлахдаа Санхүүгийн албаны 1 нягтлан бодогчийн орон тоог хасаж нягтлан бодогчид ногдох ажлын ачааллыг нэмэгдүүлсэн байна.
- ❖ Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс Биндэр сумын Санхүүгийн албаны төсөв, төрийн сангийн мэргэжилтэнд гүйлгээг хянах болон батлах эрхийг давхардуулан олгосон нь төрийн сангийн гүйлгээнд тавих хяналтыг сулруулах, зөрчилтэй гүйлгээг хянаж батлах эрсдэлийг бий болгосон байна.
- ❖ Санхүүгийн албаны даргын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэхийг сумын Засаг даргад, төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэхийг Засаг даргын Тамгын газрын даргад даалгасан Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 2028 дугаар тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна.
- ❖ Сумдын Санхүүгийн алба нь санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгохдоо Төрийн сангийн үйл ажиллагааны журамд заасан хугацааг баримтлахгүй, батлагдсан маягтыг хөтлөн баталгаажуулахгүй, санхүүжилтэд тавих хяналт алдагдаж байгаад Санхүү, төрийн сангийн хэлтэс анхаарч ажиллах шаардлагатай байна.
- ❖ Төсвийн байгууллагын бэлэн мөнгөний зарцуулалттай холбоотой журмын заалтыг хэрэгжүүлээгүйгээс төсвийн байгууллагууд бэлэн мөнгийг эд хариуцагчийн дансаар дамжуулан хөрөнгийг хяналтгүй зарцуулах эрсдэлийг бий болгож байна.
- ❖ Төсвийн зарлагын гүйлгээг анхан шатны баримтын бүрдэл дутуу, зориулалт бус, эдийн засгийн ангилал зөрүүтэй байхад хянаж, баталснаас зөрчил давтагдаж байна.
- ❖ "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.5.8 дахь заалтыг зөрчин сарын сүүлийн ажлын өдөр гүйлгээ хаах хугацааг баримтлахгүй баталгаажуулж байна.
- ❖ Төсвийн байгууллагууд орлогын хуулгыг өдөр тутам хянахгүй, журамд заасан хугацаанд нэр, данс зөрүүтэй гүйлгээний залруулах хүсэлтийг харьяа төрийн санд хүргүүлэхгүй байгаа нь Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4.21-т заасантай нийцэхгүй байна.
- ❖ Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумын Санхүүгийн алба нь төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээг гаргахдаа Төрийн сангийн үйл ажиллагааны "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 12, 22, 30, 31 дүгээр хавсралтаар батлагдсан маягтыг бүрэн хөтлөн баталгаажуулж, тооцоо нийлж ажиллаагүйгээс төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан хугацаандаа, үнэн зөв гарахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.
- ❖ Сумдын Санхүүгийн алба нь үйл ажиллагааны эрсдэлийг бодитой үнэлэхгүй, аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн дотоод хяналт хариуцсан албан тушаалтан нь эрсдэлийн үнэлгээг нягтлах үүргээ хэрэгжүүлэхгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга-д:

- ✓ Санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх ажлыг зохион байгуулж, Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 208 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах;
- ✓ Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 23, 24 дүгээр хавсралт маягтаар баталгаажуулан санхүүжилтийг олгох, хяналт хэрэгжүүлэх;
- ✓ Шаардлагатай байгууллагад журмын дагуу жижиг мөнгөн санг байгуулж, хяналт тавьж ажиллах;
- ✓ Төсөв хоорондын тооцооны тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээнд залруулга хийлгэх хүсэлт, барьцаа хөрөнгийн зардлын гүйцэтгэл, захиалагчийн хяналтын гүйцэтгэлийг батлагдсан маягтын дагуу бүрэн хөтөлж, баталгаажуулах;
- ✓ Сумдын төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтыг эрсдэлд суурилан төлөвлөж, хэрэгжүүлэх, зөвлөмжийн биелэлтийг тооцож, холбогдох арга хэмжээг авч ажиллах;
- ✓ Харьяа төрийн сангаас ирүүлсэн эрсдэлийн үнэлгээг нягталж, дахин үнэлэх, өдөр тутмын дотоод хяналтыг тогтмолжуулж, эрсдэлээс сэргийлсэн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:

- ✓ Төрийн сангийн удирдлагын цахим системээр зөрчилтэй гүйлгээг хянаж баталсан эрх бүхий албан хаагчид хариуцлага ногдуулах талаар журамд нэмэлт оруулах;
- ✓ "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.5.8-д заасан сарын сүүлийн ажлын өдрийн 14 цагаас хойш гүйлгээ хийхгүйгээр Төрийн сангийн удирдлагын цахим системтэй уялдуулах;
- ✓ "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4.21 дэх хэсгийг зөрчсөн албан хаагчид хүлээлгэх хариуцлагын талаар журамд нэмэлт оруулах;
- ✓ Нэг албан тушаалтанд гүйлгээг хянах болон батлах эрхийг давхардуулан олгохгүйн тулд тухайн орон тоо нөхөгдөх хүртэл хугацаагаар аймгийн төрийн сангийн холбогдох албан тушаалтанд түр шилжүүлдэг байх зохицуулалтыг "Төрийн сангийн цахим системийн заавар"-т нэмэлт өөрчлөлт оруулах

---o0o---